



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2023 оны 03 сарын 08 өдөр

Дугаар 29/04

Арвайхээр сум

Аймгийн Засаг даргын 2021 оны А/500 дугаар захирамжийн дагуу олгогдсон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зарцуулалт, худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтэд хяналт шалгалт хийсэн тухай

### Нэг. Ерөнхий зүйл

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталсан 29/08 тоот удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын 2021 оны А/500 дугаар захирамжийн дагуу олгогдсон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зарцуулалт, худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтэд “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон бусад хууль, удирдах дээд байгууллагуудын тогтоол, шийдвэр, заавар, журмуудын хэрэгжилтийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Шалгалт явуулахдаа санхүүгийн баримтыг банкны хуулга болон анхан шатны баримтууд, тайлан тооцоо бодсон актуудтай тулган баталгаажуулах, асууж тодруулах хэлбэрээр явууллаа.

### Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Шалгалтыг аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч С.Дуламжаргал, аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ч.Буянбат, Ц.Цолмонтуяа, Б.Пүрэвсүрэн нар 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хийж гүйцэтгэлээ.

### Гурав. Шалгалтад хамрагдсан асуудлын талаар

**3.1 Захирамжийн дагуу олгогдсон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх:**

- Усан спорт сургалтын төвийн тоног төхөөрөмжийн зардлын 47,550,000 (дөчин долоон сая таван зуун тавин мянган) төгрөгийг 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Арвайкассандра ХХК-ийн 5099077879 тоот дансанд шилжүүлсэн. Усан спорт сургалтын төвд Арвайкассандра ХХК-иас 27,270,000 (хорин долоон сая хоёр зуун далан мянга) төгрөгийн тоног төхөөрөмж, 20,280,000 (хорин сая хоёр зуун наян мянга) төгрөгийн тавилгыг

692902007



Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Усан спорт сургалтын төвийн удирдлагууд байлцан ажил хүлээлцсэн акт үйлдэн хүлээн авсан;

- Улсын бүртгэлийн хэлтсийн тоног төхөөрөмжийн зардалд 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөг олгосноос Очир ай гүүгэл ХХК-тай вэб систем нийлүүлэх гэрээ болон тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ байгуулан, 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдөр дугаар дуудагч машиныг худалдан авахад 6,169,000 (зургаан сая нэг зуун жаран есөн мянга) төгрөгийг, үнэлгээний вэб системийн зардалд 1,331,000 (нэг сая гурван зуун гучин нэгэн мянга) төгрөгийг тус тус зарцуулсан;

- Нарийнтээл сумын ЗДТГазарт автомашины засварын зардалд 10,000,000 (арван сая) төгрөг, хүндэтгэлийн хаалганы тохижилтод 8,000,000 (найман сая) төгрөг олгосноос иргэн С.Ганзоригтой “Авто зогсоол байгуулах” 6,000,000 (зургаан сая) төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн бөгөөд 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/197 дугаар захирамжаар ажил хүлээлцэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажил хүлээлцэх актаар хүлээн авсан. Фургон автомашиныг засварлах зардалд 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг Автоком хөсөг хүрд ХХК-иар гүйцэтгүүлж, хүндэтгэлийн хаалганы тохижилтын зардлаас хэмнэгдсэн 2,000,000 (хоёр сая) төгрөгийг авто машины засварын зардалд зориулалт бусаар зарцуулсан;

- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын авто машины засварын зардалд 3,100,000 (гурван сая нэг зуун мянга) төгрөгийг олгосон бөгөөд Смарт өнжине ХХК-иар Ланд-100 авто машины засварын ажлыг 3,100,000 (гурван сая нэг зуун мянга) төгрөгөөр гүйцэтгүүлсэн;

- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын тавилга тоног төхөөрөмжийн зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийг олгосноос Тэрэмбаян ХХК-иар 2,800,000 (хоёр сая найман зуун мянга) төгрөгийн үнэ бүхий Лед хаягийг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хийлгэж, үлдэгдэл 7,200,000 (долоон сая хоёр зуун мянга) төгрөгийг оны эцэст төвлөрүүлж, 2022 оны 12 дугаар сарын 24-нд тавилга эд хогшлын зардалд тусгуулах тухай хүсэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст өгч шийдвэрлүүлэн, Хашхан ХХК-тай тавилга худалдах, худалдан авах гэрээг байгуулж, бичгийн шүүгээ 2,250,000 (хоёр сая хоёр зуун тавин мянга) төгрөг, хувцасны шүүгээ 2,120,000 (хоёр сая нэг зуун хорин мянга) төгрөг, хурлын ширээний сандал 2,560,000 (хоёр сая таван зуун жаран мянга) төгрөг, оффис сандал 270,000 (хоёр зуун далан мянга) төгрөгөөр тус тус худалдан авсан;

- Өлзийт сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Сумын 2022 оны төсөв батлах тухай” 6/04 дүгээр тогтоолын хавсралтаар урд оны үлдэгдлээс Цагдаагийн автомашин авах зардалд 11,800,000 (арван нэгэн сая найман зуун мянга) төгрөгийг баталж, сумын ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансанд 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр цагдаагийн хэсгийн автомашин худалдан авахад дэмжлэг болгон 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийн орлого аймгийн ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн данснаас оны сүүлд шилжин орж ирсэн тул үлдэгдэлд төвлөрүүлэн, 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр 17,800,000 (арван долоон сая найман зуун мянга)



төгрөгөөр цагдаагийн автомашиныг иргэн Ц.Лхагважаваас худалдан авахаар зарцуулалт хийсэн;

- Хархорин сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 01/296 тоотор Сангийн яаманд Хархорин-Ус суваг ОНӨААТҮГазарт ус зөөврийн автомашин худалдан авах төсөвт өртгийг 40,000,000 (дөчин сая) төгрөгөөр нэмэгдүүлэн, 85,000,000 (наян таван сая) төгрөг болгон сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж байгаа тул баталж өгнө үү гэсэн хүсэлтийг явуулж, Солонгос улсаас автомашин нийлүүлэгчдийн холбоо ТББайгууллагаас 2022 оны 12 сарын 01-ний өдөр 84,800,000 (наян дөрвөн сая найман зуун мянга) төгрөгөөр худалдан авсан;

- Үйлчилгээний нэгдсэн төвийн компьютер, техник хэрэгслэлийн зардлын 10,000,000 (арван сая) төгрөг 2021 оны 11 дүгээр сарын 03-нд харилцах дансанд нь орж, 2021 оны 11 дүгээр сарын 11-нд Номин бизнес клуб ХХК Арвайхээр салбарт 9,119,970 (есөн сая нэг зуун арван есөн мянга есөн зуун дал) төгрөгийн нэг бүр нь 3,039,990 (гурван сая гучин есөн мянга есөн зуун ер) төгрөгийн үнэ бүхий 3 зөөврийн компьютерийн үнэ, иргэн Г.Батчимэгт 880,030 (найман зуун наян мянга гуч) төгрөгийн принтер техник хэрэгслэлийн үнийг тоног төхөөрөмж зардлаас тус тус шилжүүлсэн;

- Зүүнбаян-Улаан сумын ЭМТ-ийн засварын зардлын 9,700,000 (есөн сая долоон зуун мянга) төгрөг 2021 оны 12 дугаар сарын 03-нд нэмэлт санхүүжилтийн дансанд орж, 2021 оны 12 дугаар сарын 13-нд Элбэг төв иргэн Т.Батнямд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн хулдаасны үнэ, Өв Од Барилга барилгын материалын дэлгүүрт 7,700,000 (долоон сая долоон зуун мянга) төгрөгийн материалын үнийг урсгал засварын зардлаас тус тус шилжүүлсэн;

- Хархорин сумын 5 дугаар цэцэрлэг 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн уурын зуухны тогоо, гэрэл цахилгаан тасарсан үед уурын зуухаа хөлдөөхгүй ажиллуулах зорилгоор 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөгийн зөөврийн моторыг худалдан авсан;

- Арвайхээр сумын 1 дүгээр цэцэрлэг нь дотор сантехник, засварын зардалд 14,000,000 (арван дөрвөн сая) төгрөгийг зарцуулахаас дотор сантехникийн засварыг "Дэлгэр аз хур" ХХК-иар 12,000,000 (арван хоёр сая) төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлж, иргэн Д.Найманжингаас 2,000,000 (хоёр сая) төгрөгийн засварын материал худалдан авч засвар үйлчилгээг (урлаг заалны хаалт) хийсэн;

- Аймгийн Цагдаагийн газарт 20,000,000 (хорин сая) төгрөгийг эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны засварын зориулалтаар олгосноос: Ану компьютерс лайн ХХК-иас 1,177,000 (нэг сая нэг зуун далан долоон мянга) төгрөгийн проектор, Дриймвиннер ХХК-иас 1,485,000 (нэг сая дөрвөн зуун наян таван мянга) төгрөгийн суултуур, БСБ Оффисс мебель ХХК-иас 1,939,800 (нэг сая есөн зуун гучин есөн мянга найман зуу) төгрөгийн шкаф, Өв Од барилга ХХК-иас 7,300,500 (долоон сая гурван зуун мянга таван зуу) төгрөгийн засварын материал Д.Найманжингаас 8,097,700 (найман сая ерэн долоон мянга долоон зуу) төгрөгийн материал худалдан авсан. Засварын төсвөөс нийт 3,116,800 (гурван сая нэг



зуун арван зургаан мянга найман зуу) төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байгааг баримтаар шалгахад 2021 онд эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрыг тохижуулахаар аймгийн Засаг даргад хөрөнгө шийдвэрлэж өгөх тухай хүсэлт, төсвийн хамт хүргүүлсэн төсөвт баривчлагдсан этгээдийн хувцас хадгалах шкаф, сургалтанд хэрэглэх проектор, мөн байрны засварыг тусгасаныг нийт дүнгээр шийдвэрлэж өгсөн тул 3,116,800 (гурван сая нэг зуун арван зургаан мянга найман зуу) төгрөгийг тоног төхөөрөмжийн зардлаас шилжүүлсэн;

- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний байрны гадна бохирын холболтын ажлыг Онги Ус суваг ОНӨХХК-иар 3,500,000 (гурван сая таван зуун мянга) төгрөгөөр гүйцэтгүүлэхээр санхүүжилт өгсөнөөс, засвар үйлчилгээ, материалын зардалд 940,272 (есөн зуун дөчин мянга хоёр зуун далан хоёр) төгрөг, бохирын машины шатахууны зардалд 230,000 (хоёр зуун гучин мянга) төгрөг, үйлчилгээний машины шатахууны зардалд 100,000 (нэг зуун мянга) төгрөг, нэг удаагийн ажлын хувцас 145,000 (нэг зуун дөчин таван мянга) төгрөг, хөдөлмөр хамгаалал бээлий 17,500 (арван долоон мянга таван зуу) төгрөг, Кольцо худалдан авахад 780,466 (долоон зуун наян мянга дөрвөн зуун жаран зургаа) төгрөг нийт 2,213,238 (хоёр сая хоёр зуун арван гурван мянга) төгрөгийн зардал гарсан;

- Арвайхээр сумын 14 дүгээр цэцэрлэгийн гадна төмөр хашаа барих угсралтын ажлыг Шүүтийн өндөр ХХК-иар 12,000,000 (арван хоёр сая) төгрөгөөр гүйцэтгүүлсэн. Ажил гүйцэтгүүлэх гэрээг (БУ-09/2021 дугаартай) аймгийн Засаг даргын Тамгын газрын ХОХБТХэлтсийн дарга Ч.Гүнсэнхорол, Шүүтийн өндөр ХХК-ийн захирал Ч.Ганбаатар нар 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулж, 10 дугаар сарын 25-ны өдрийн БУ-09/2021 дугаартай барилга байгууламжийн засварын ажлыг хүлээн авах 5 хүний бүрэлдэхүүнтэй комиссын дүгнэлтээр тус ажлыг хүлээн авсан;

- Арвайхээр сумын 11 дүгээр тусгай цэцэрлэгт дотор засварын зориулалтаар 6,000,000 (зургаан сая) төгрөг олгосныг цэцэрлэгт үүссэн мөөгөнцөрийг арилгахаар 2021 оны 11 дүгээр сарын 12-нд Од барилга ХХК-иас 3,934,600 (гурван сая есөн зуун гучин дөрвөн мянга зургаан зуу) төгрөгийн засварын материал, Дэлгэр аз хур ХХК-иас 561,600 (таван зуун жаран нэгэн мянга зургаан зуу) төгрөгийн засварын материал, Хөгшин хайрхан шүтээн ХХК-иас 462,650 (дөрвөн зуун жаран хоёр мянга зургаан зуун тавь) төгрөгийн засварын материал, Эрдэнийн гурвалжин ХХК-иас 298,000 (хоёр зуун ерэн найман мянга) төгрөгийн засварын материал, Цуврайн гол ХХК-иар 387,500 (гурван зуун наян долоон мянга таван зуу) төгрөгийн ариутгал хийлгэж, Эм гоо ХХК-иас 249,600 (хоёр зуун дөчин есөн мянга зургаан зуу) төгрөгийн мөөгөнцөрийн эсрэг эм, Аура-ундрах ХХК-иас 180,000 (нэг зуун наян мянга) төгрөгийн гар ариутгагч, халуун хэмжигч худалдан авч нийтдээ 6,073,950 (зургаан сая далан гурван мянга есөн зуун тавь) төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан;

- Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь Элемент медициналь ХХК-иас 6,763,000 (зургаан сая долоон зуун жаран гурван мянга) төгрөгийн эмнэлэгийн зориулалттай хогийн савны уут, Хан жаргалант ХХК-иас 7,066,100 (долоон сая жаран зургаан мянга нэг зуу)



төгрөгийн, Хобби төвөөс 2,870,900 (хоёр сая найман зуун далан мянга есөн зуу) төгрөгийн нийт 16,700,000 (арван зургаан сая долоон зуун мянга) төгрөгийн материал худалдан авч бараа материалын тайланд тусгасан;

- Хайрхандулаан сумын ЗДТГазрын тавилга, техник хэрэгслэлийн зардлын 20,000,000 (хорин сая) төгрөг 2021 оны 11 дүгээр сарын 10-нд нэмэлт санхүүжилтийн дансанд орж, 11 дүгээр сарын 24-нд Улаанбаатар буйдан хийц компанид 2,310,000 (хоёр сая гурван зуун арван мянга) төгрөгийн арьсан буйдангийн үнэ, Говь хангай мебельд 510,000 (таван зуун арван мянга) төгрөгийн ширээний үнэ, Борх гранд компанид 3,200,000 (гурван сая хоёр зуун мянга) төгрөгийн нэг бүр нь 160,000 (нэг зуун жаран мянган) төгрөгийн үнэ бүхий 20 ширхэг ширээний үнэ, иргэн Э.Болор-Эрдэнэд 757,000 (долоон зуун тавин долоон мянга) төгрөгийн сандлын үнэ, Дэмт ХХК-д 1,538,000 (нэг сая таван зуун гучин найман мянган) төгрөгийн ширээ, сандлын үнэ, 11 дүгээр сарын 25-нд Нэкст электроникс компанид 4,219,700 (дөрвөн сая хоёр зуун арван есөн мянга долоон зуу) төгрөгийн телевизор, кабелийн үнэ, Говь хангай мебельд 2,807,000 (хоёр сая найман зуун долоон мянга) төгрөгийн тавилгын үнэ, БСБ оффис мебель компанид 3,416,000 (гурван сая дөрвөн зуун арван зургаан мянга) төгрөгийн сандлын үнэ, 12 дугаар сарын 01-нд Дэмт ХХК-д 800,000 (найман зуун мянга) төгрөгийн шкафны үнэ, 12 дугаар сарын 23-нд 1,042,300 (нэг сая дөчин хоёр мянга гурван зуу) төгрөгийн шкафны үнэ, нийт 20,600,000 (хорин сая зургаан зуун мянган) төгрөгийг тавилгын зардлаас тус тус шилжүүлсэн;

- Япон улсын элчин сайдын яам, аймгийн Засаг даргатай 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан гэрээ, Япон улсын элчин сайдын яамнаас ирүүлсэн 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн албан бичгийг үндэслэн Мэргэд лаборатори сургуулийн Япон хэлний кабинетын тохижилтын нэмэлт санхүүжилтийн зардлын 42,300,000 (дөчин хоёр сая гурван зуун мянга) төгрөгийг 2021 оны 12 дугаар сарын 27-нд Мэргэд лаборатори сургуулийн япон хэл сурах орчныг сайжруулах төслийн хүрээнд Өвсний үндэс төслийн дансанд шилжүүлсэн;

- Өв агро гурил тэжээлийн үйлдвэрийн авто машины засвар, тоног төхөөрөмжийн зардлын 21,600,000 (хорин нэгэн сая зургаан зуун мянга) төгрөг 2021 оны 11 дүгээр сарын 30-нд харилцах дансанд нь орж, 12 дугаар сарын 10-нд иргэн Ч.Ишгямцайд 5,000,000 (таван сая) төгрөгийн машин засварын үнэ, 12 дугаар сарын 14-нд Татах хүч моторс компанид 5,170,000 (таван сая нэг зуун далан мянга) төгрөгийн машин засварын үнэ, 12 дугаар сарын 16-нд иргэн Ч.Ишгямцайд 3,500,000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийн машин засварын үнэ, 12 дугаар сарын 31-нд иргэн Ч.Ишгямцайд 7,930,000 (долоон сая есөн зуун гучин мянга) төгрөгийн машин засварын үнэ, нийт 21,600,000 (хорин нэгэн сая зургаан зуун мянга) төгрөгийг шилжүүлсэн;

- Бат-Өлзий сумын ЗДТГазрын автомашин худалдан авах зардлын 50,000,000 (тавин сая) төгрөг 2021 оны 11 дүгээр сарын 24-нд ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансанд орж, Орон нутгийн орлогоос 20,000,000 ( хорин сая ) төгрөг нэмж, Флоу процесс ХХК-иас Ланд-



105 машиныг 69,990,000 (жаран есөн сая есөн зуун ерэн мянга) төгрөгөөр худалдан авч, төлбөрийг гэрээний дагуу 3 хувааж Флоу процесс ХХК-д шилжүүлсэн;

- Татварын хэлтэст автомашин худалдан авах зардлын 20,000,000 (хорин сая) төгрөг 2021 оны 11 дүгээр сарын 02-нд Татварын хэлтсийн дансанд орж, “Богдын буян” ХХК-иас 2005 онд үйлдвэрлэгдсэн 2021 онд Монголд орж ирсэн хар өнгөтэй TOYOTA PRIUS-20 маркийн машиныг 20,000,000 (хорин сая) төгрөгөөр худалдан авч, хөрөнгийг хүлээн авах акт үйлдэн 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Богдын буян ХХК-ийн 5540302001 тоот дансанд мөнгийг шилжүүлсэн;

- Уянга сумын Ахмадын хорооны байранд дээврийн болон дотоод засвар 35,000,000 (гучин таван сая) төгрөгөөр хийгдэж, аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвөөс 10,000,000 (арван сая) төгрөг санхүүжүүлж, Уянга сумын ахмадын хорооны дарга Г.Ганбаатарт шилжүүлсэн;

- Хархорин сумын Цагдаагийн хэлтэс нь УБЦНЗ ХХК-иас 15,000,000 (арван таван сая) төгрөгийн засварын материал авч, 2021 оны 12 дугаар сарын 16-нд тухайн байгууллагын 5561158814 тоот дансанд шилжүүлсэн;

- Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/500 дугаар захирамжийн хавсралтаар аймгийн ЗДТГазарт автомашин худалдан авахад дэмжлэг болгон 73,050,000 (далан гурван сая тавин мянга) төгрөгийг зарцуулах шийдвэр, аймгийн ЗДТГазрын даргын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/247 дугаар тушаалаар Тамгын газрын автомашины шинэчлэлд 42,000,000 (дөчин хоёр сая) төгрөгийг захиалагчийн хяналтын зардлаас зарцуулах шийдвэрүүд тус тус гарсаны дагуу 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Бага хөгшин ХХК-иас 115,000,000 (нэг зуун арван таван сая) төгрөгөөр аймгийн Онцгой комисст туулах чадвар сайтай Land cruiser 200 маркийн суудлын автомашиныг комиссын ОНТ-4 дугаартай актаар хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулалтыг хийжээ.

### **3.2 Анхан шатны баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт:**

- Усан спорт сургалтын төвийн үндсэн хөрөнгөнд 46,050,000 (дөчин зургаан сая тавин мянга) төгрөг, бараа материалд 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг бүртгэж тайландаа тусгасан;

- Улсын бүртгэлийн хэлтэс нь дугаар дуудагч машиныг машин тоног төхөөрөмжид, үнэлгээний вэб системийг программ хангамжид орлого авч, тайланд тусгасан;

- Нарийнтээл сумын ЗДТГ нь хүндэтгэлийн хаалгыг капиталжуулан үндсэн хөрөнгөд бүртгэсэн, фургон автомашины засварын материалыг бараа материалд орлого авч, шууд зарлагдсан бөгөөд техник ашиглалтын паспорт байхгүй;

- Байгаль орчин, аялал жуулчлалын газар 1,546,870 (нэг сая таван зуун дөчин зургаан мянга найман зуун дал) төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 535,230 (таван зуун гучин таван мянга хоёр зуун гуч) төгрөгийг түлш шатахууны тайланд орлогоор бүртгэж шаардах хуудсаар олгосон бөгөөд шаардах хуудсыг буруу бичсэн, зөвшөөрөл олгоогүй, байгууллагын даргын



гарын үсэггүй, тамгагүй хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар олгосон байна. Техник ашиглалтын паспортод авто машины засварын тухай бичилтийг бүрэн хийсэн;

- Өлзийт сумын Эрсдэлээс хамгаалах сангийн данснаас 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр 17,800,000 (арван долоон сая найман зуун мянга) төгрөгөөр цагдаагийн автомашиныг иргэн Ц.Лхагважаваас худалдан авч, сумын ЗДТГазрын үндсэн хөрөнгийн тээврийн хэрэгсэлд бүртгэн капиталжуулсан;

- Хархорин-Ус суваг ОНӨААТҮГазар үндсэн хөрөнгөд тээврийн хэрэгслийг 84,800,000 (наян дөрвөн сая найман зуун мянга) төгрөгөөр капиталжуулсан;

- Үйлчилгээний нэгдсэн төв нь и-баримтуудыг үндэслэн зардлыг шилжүүлж, нэг бүр нь 3,039,990 (гурван сая гучин есөн мянга есөн зуун ер) төгрөгийн үнэ бүхий 3 зөөврийн компьютер, 730,000 (долоон зуун гучин мянга) төгрөгийн үнэ бүхий принтер, 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн үнэ бүхий вэб камер, 30,000 (гучин мянга) төгрөгийн үнэ бүхий спикер, 20,030 (хорин мянган гуч) төгрөгийн үнэ бүхий микрофоныг хөрөнгийн орлогод авсан;

- Зүүнбаян-Улаан ЭМТ нь и-баримтуудыг үндэслэн зардлыг шилжүүлж, 9,700,000 (есөн сая долоон зуун мянга) төгрөгийн материалыг орлогод авч, зарцуулсан;

- Хархорин сумын 5 дугаар цэцэрлэг үндсэн хөрөнгөд барилга байгууламжийг 4,000,000 (дөрвөн сая) төгрөгөөр, машин тоног төхөөрөмжийг 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр капиталжуулан бүртгэсэн;

- Арвайхээр сумын 1 дүгээр цэцэрлэг үндсэн хөрөнгөд барилга байгууламжийг 14,000,000 (арван дөрвөн сая) төгрөгөөр капиталжуулан бүртгэсэн;

- Цагдаагийн газар нь эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны засварт Ану компьютерс ллайн ХХК-иас 1,177,000 (нэг сая нэг зуун далан долоон мянга) төгрөгийн проектор худалдан авч үнийг шилжүүлэхдээ и-баримтыг хавсаргаагүй. 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн орлогын баримтаар 1,177,000 (нэг сая нэг зуун далан долоон мянга) төгрөгийн проекторыг тоног төхөөрөмж дансанд, 1,939,800 (нэг сая есөн зуун гучин есөн мянга найман зуу) төгрөгийн шкафыг тавилга эд хогшлын дансанд үндсэн хөрөнгөөр бүртгэж, барилга засварын материалын 11 дүгээр сарын тайланд 15,398,200 (арван таван сая гурван зуун ерэн найман мянга хоёр зуу) төгрөгийн материалыг орлогоор бүртгэж шаардах хуудасны дагуу зарцуулсан;

- Онги Ус суваг ОНӨХХК Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний байрны гадна бохирын холболтын ажлыг гүйцэтгэхэд 2,213,238 (хоёр сая хоёр зуун арван гурван мянга хоёр зуун гучин найм) төгрөгийн засвар үйлчилгээний материалыг зарцуулж, бараа материалын тайланд орлогоор бүртгэн шаардах хуудасны дагуу зарцуулсан;

- Арвайхээр сумын 14 дүгээр цэцэрлэг гадна хайс хийлгэсний төлбөр 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг Шүүтийн өндөр ХХК руу нэхэмжлэх, төлбөрийн баримт, ажлын гүйцэтгэл, хурлын тэмдэглэл, гүйцэтгэсэн ажлыг ашиглалтанд оруулах комиссын



дүгнэлтийг үндэслэн шилжүүлж, үндсэн хөрөнгийн барилга байгууламжид орлогоор бүртгэсэн;

- Арвайхээр сумын 11 дүгээр тусгай цэцэрлэг нь 6,073,950 (зургаан сая далан гурван мянга есөн зуун тавь) төгрөгийн засварын материалыг бараа материалын тайланд орлогоор бүртгэн шаардах хуудасны дагуу зарцуулсан;

- Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 16,700,000 (арван зургаан сая долоон зуун мянга) төгрөгийн материал худалдан авч, бараа материалын тайланд орлогоор бүртгэн шаардах хуудасны дагуу зарцуулсан;

- Хайрхандулааны ЗДТГ нь и-баримтуудыг үндэслэн зардлыг шилжүүлсэн боловч 1,042,300 (нэг сая дөчин хоёр мянга гурван зуу) төгрөгийн и-баримт дутуу, тавилга, тоног төхөөрөмжийг хөрөнгийн орлогод авсан;

- Өв агро гурил тэжээлийн үйлдвэр нь 16,430,000 (арван зургаан сая дөрвөн зуун гучин мянга) төгрөгийн и-баримт дутуу байхад зардлыг шилжүүлсэн, бараа материалын тайланд машины сэлбэгийг орлогод авч, машины сэлбэгэнд 5,000,000 (таван сая) төгрөгийн үнэ бүхий мотор, 5,170,000 (таван сая нэг зуун далан мянга) төгрөгийн үнэ бүхий апартур зэрэг капиталжуулах хөрөнгө байхад капиталжуулж тайланд тусгалгүйгээр шууд зарлагдсан, аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/216 дугаар захирамжаар Нарийнтээл сумын ЗДТГ-т ашиглагдаж байсан Ланд Крузер-100 маркийн 64-22 ӨВР улсын дугаартай автомашиныг балансаас балансад шилжүүлэн авсан ч автотехникийн паспорт нь шилжиж ирээгүй гэдэг шалтгаанаар автотехникийн паспортыг хөтлөөгүй;

- Бат-Өлзий сумын ЗДТГ нь Ланд-105 автомашиныг сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/182 дугаар захирамжаар ажлын хэсэг гарч хүлээн авах акт үйлдэн үндсэн хөрөнгөнд бүртгэж, тайланд тусгасан;

- Татварын хэлтэс нь TOYOTA PRIUS-20 автомашиныг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэж, техник ашиглалтын паспортыг хөтөлж ашигладаг;

- Хархорин сумын Цагдаагийн хэлтэс нь засварын материалыг бараа материалын тайланд тусгаж, зарцуулсан;

- Аймгийн ЗДТГазар 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тээврийн хэрэгсэлд 115,000,000 (нэг зуун арван таван сая) төгрөгөөр бүртгэн капиталжуулсан.

### **3.3 Төсвийн хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, ашиглалт зарцуулалт, үр дүн:**

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 08-ны А/168 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Усан спорт сургалтын төвийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж, 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдөр нээлт хийхэд Арвайн нүнжиг ХХК, Арвайкассандра ХХК 2 аж ахуйн нэгж үнийн саналаа ирүүлж, Арвайкассандра ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдөр тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ байгуулж, 2020 оны 12 дугаар



сарын 16-ны өдөр Усан спорт сургалтын төвд тавилга, тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж дуусгасан;

- Өлзийт сумын ЗДТГ иргэн Ц.Лхагважавтай цагдаагийн Toyota probox van автомашин худалдан авах гэрээг 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр 17,800,000 (арван долоон сая найман зуун мянга) төгрөгөөр хийж, шууд худалдан авалт хийсэн;

- Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/274 дүгээр захирамжаар Хархорин-Ус суваг ОНӨААТҮГазарт ус зөөврийн автомашин авах зардалд 40,000,000 (дөчин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Хархорин сумын ЗДТГазарт шилжүүлж, худалдан авах ажиллагааг зохих хууль, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг тайлагнахыг сумын Засаг даргад үүрэг болгосны дагуу Хархорин сумын ЗДТГазрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулагдаж, үнэлгээний хороо 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хуралдан, тендерийн урилга, баримт бичгийг tender.gov.mn цахим системд 10 дугаар сарын 05-ны өдөр байршуулан, 11 дүгээр сарын 07-ны өдрийн 15 цаг 30 минутад тендерийг нээхэд Солонгос улсаас автомашин нийлүүлэгчдийн холбоо ТББ 84,800,000 (наян дөрвөн сая найман зуун мянга) төгрөгөөр үнийн санал ирүүлжээ. Үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдлийг гаргасан боловч удирдах дээд албан тушаалтнаар баталгаажуулалтыг хийлгүүлээгүй, үнэлгээний хорооны гишүүдийн 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцэн Солонгос улсаас автомашин нийлүүлэгчдийн холбоо ТББ-аар нийлүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэн, үнэлгээний хорооны 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 2022/38 дугаар зөвлөмжийн дагуу Солонгос улсаас автомашин нийлүүлэгчдийн холбоо ТББ-аар 84,800,000 (наян дөрвөн сая найман зуун мянга) төгрөгөөр нийлүүлэх, гэрээ байгуулан худалдан авалт хийх, тендер гүйцэтгэгчийг сонгох тухай сумын ЗДТГазрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/93 дугаар тушаал гарч, 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 12 дугаар сарын 21-ний дотор нийлүүлэхээр ӨВАХХСЗДТГ202209049 дугаартай гэрээг байгуулан, 11 дүгээр сарын 23-ны өдөр импортлогдсон ус зөөврийн автомашиныг 12 дугаар сарын 01-ний өдрийн ус зөөврийн автомашин хүлээлцсэн актаар хүлээн авчээ;

- Хархорин сумын 5 дугаар цэцэрлэг Анд Ану трейдинг ХХК-тай 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдөр уурын зуухны тогоо 4,000,000 (дөрвөн сая) төгрөгөөр худалдан авахаар ӨВАХСӨБ/2021-73 дугаартай гэрээг байгуулж, худалдан авалтыг хийсэн;

- Мэргэд лаборатори сургуулийн Япон хэлний цахим кабинетын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, анги засварын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нээлттэй сонгон шалгаруулалтаар 2 удаа зарлаж тендерийн санал ирээгүйгээс, аймгийн ЗДТГ-ын даргын 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн "Тендер хүчингүй болгож, шууд гэрээ байгуулах тухай" А/196 дугаар тушаал, холбогдох хуулийн дагуу орон нутгийн 3 компаниас үнийн санал авч, Японы элчин сайдын яаманд явуулсан боловч шаардлага хангаагүй гэж үзэж, Японы элчин сайдын яамны Өвсний үндэс хөтөлбөрөөр хэрэгжсэн



өмнөх төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн компаниудад саналын урилга хүргүүлж, үнийн санал авч, техникийн тодорхойлолт болон “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, Баян их наяд ХХК шалгарч, гэрээ байгуулан 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгсөн;

- Өв агро гурил тэжээлийн үйлдвэр нь автомашины засвар үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудаас үнийн санал авч харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх байсан боловч худалдан авах ажиллагааны журмыг зөрчин, шууд худалдан авалтын аргаар ажил гүйцэтгүүлсэн;

- Бат-Өлзий сумын ЗДТГазар тээврийн хэрэгсэл худалдан авах тендерийг 2 удаа зарлаж тендерт ганц Флоу процесс ХХК-ийн санал ирж 69,990,000 (жаран есөн сая есөн зуун ерэн мянга) төгрөгөөр Ланд 105 машиныг худалдан авах гэрээг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр байгуулж, төлбөрийг гэрээний дагуу 3 хувааж шилжүүлсэн. Тээврийн хэрэгслийг сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/182 дугаар захирамжаар ажлын хэсэг гаргаж хүлээн авах акт үйлдэн хүлээн авчээ;

- Татварын хэлтсийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар эд хөрөнгө худалдаж авах ажлын хэсэг байгуулан, үнийн санал авах зарлал тавьж, Бишрэлт наран ХХК, Богдын буян ХХК, Мэжик бонд ХХК-иас үнийн санал ирсэнээс хамгийн бага үнийн санал ирүүлсэн Богдын буян ХХК-иас 20,000,000 (хорин сая төгрөг) төгрөгөөр PRIUS-20 маркийн автомашиныг худалдан авсан;

- Аймгийн ЗДТГазрын 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/207 дугаар тушаалаар аймгийн ЗДТГазарт автомашин худалдаж авах тендер гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, үнэлгээний хорооны гишүүд 10 дугаар сарын 13-ны өдөр хуралдан, техникийн тодорхойлолтыг боловсруулан, тендерийг яаралтай зарлахыг үнэлгээний хорооны нарийн бичгийн даргад даалгасаны дагуу тендерийн баримт бичгийг боловсруулан, тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд санхүүжилтийн нийт төсөвт өртөг 105,000,000 (нэг зуун таван сая) төгрөг, тендер нээлт хийх хугацаа 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 09 цаг 30 минут байхаар тусган тендерийг зарлахад нэг ч тендер оролцогч санал ирүүлээгүй тул үнэлгээний хорооны 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлаар төсөвт өртөгийг 10,000,000 (арван сая) төгрөгөөр нэмэгдүүлэн хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар дахин зарлахаар шийдвэрлэж, аймгийн ЗДТГазрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/234 дүгээр тушаалаар шаардлага хангасан нэг ч тендер ирээгүй тул уг тендерээс татгалзан дахин тендерийг зохион байгуулахаар шийдвэрлэн, 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 09 цаг 30 минутад тендерийн нээлт хийхэд Бага хөгшин ХХК 115,000,000 (нэг зуун арван таван сая) төгрөгөөр үнийн санал ирүүлэхэд үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдлийг гаргаагүй, үнэлгээний хорооны 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцэн, Бага хөгшин ХХК-иар гүйцэтгүүлэхээр



шийдвэрлэж, аймгийн ЗДТГазрын даргад 02 дугаартай зөвлөмжийг хүргүүлж, аймгийн ЗДТГазрын даргын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/246 дугаар тушаалаар аймгийн Онцгой комисст туулах чадвар сайтай автомашин худалдан авах ажлыг Бага хөгшин ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсний дагуу тус компанид гэрээ байгуулах эрх олгосныг мэдэгдэж, 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр ОНТ-04 дугаартай гэрээг байгуулан худалдан авалтыг хийжээ.

**Дөрөв. Шалгагдсан байгууллага аж ахуйн нэгжид өгсөн дүгнэлт**


Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/500 дугаар захирамжаар Баянтээг ХК-ийн Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн 500,000,000 (таван зуун сая) төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зарцуулалтад хамрагдсан 25 байгууллагын холбогдох санхүүгийн баримт, тендер шалгаруулалт, худалдан авалтын баримтад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар Нарийнтээл сумын ЗДТГ нь хүндэтгэлийн хаалганы тохижилтын зардлаас хэмнэгдсэн 2,000,000 (хоёр сая) төгрөгийг авто машины засварын зардалд зориулалт бусаар зарцуулсан, Өв агро гурил тэжээлийн үйлдвэр нь автомашины засварын зардлын машины сэлбэгэнд 5,000,000 (таван сая) төгрөгийн үнэ бүхий мотор, 5,170,000 (таван сая нэг зуун далан мянга) төгрөгийн үнэ бүхий апартаур зэрэг капиталжуулах хөрөнгө байхад капиталжуулж тайланд тусгалгүйгээр шууд зарлагдсан, аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 06-ны А/216 дугаар захирамжаар Нарийнтээл сумын ЗДТГазарт ашиглагдаж байсан Ланд Крузер-100 маркийн 64-22ӨВР улсын дугаартай автомашиныг балансаас балансад шилжүүлэн авсан ч автотехникийн паспорт нь шилжиж ирээгүй гэдэг шалтгаанаар автотехникийн паспортыг хөтлөөгүй, худалдан авах ажиллагааны журмыг зөрчин шууд худалдан авалтын аргаар ажил гүйцэтгүүлсэн, зарим байгууллагууд и-нэхэмжлэх байхгүй байхад зардлыг шилжүүлсэн зэрэг зөрчлүүд илэрч, холбогдох байгууллагуудын нягтлан бодогч нарт илэрсэн зөрчлийг арилгах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

**Тав. Цаашид анхаарах асуудлууд:**

Улс, аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнээс төсвийн байгууллагуудад олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт зориулалтын дагуу зарцуулж буй эсэх, и-нэхэмжлэх, и-баримт, зарлагын баримт зэрэг холбогдох бусад анхан шатны баримт бүрэн эсэхэд аймаг, сумдын төрийн сан хяналт тавьж ажиллах


ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  С.ДУЛАМЖАРГАЛ

АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  Ч.БУЯНБАТ



АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ




Ц.ЦОЛМОНТУЯА

АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН  
АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ЛХАМДОЛГОР

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА



Ц.ГАНБОЛД

НЯГТЛАН БОДОГЧ



О.ЦЭРЭНЧИМЭД